

Ч.Оюунбилэг, В.Энхжаргал, Ж.Ууганцэцэг
Х.Энхжаргал, С.Баасандулам, Д.Энхжаргал

ХӨГЖИМ

II

Ерөнхий боловсролын сургуулийн
2 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
X-545

Хөгжим II: Ерөнхий боловсролын сургуулийн 2 дугаар ангийн сурах бичиг
/Оюунбилэг.Ч., ба бус; Ред. Бүдхүү.Х., -УБ., 2014.- 68х./

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-65-9

ГАРЧИГ

9 сарын 1	5	Фа эгшиг	38
Тоглоно би	6	Ми эгшиг	38
Хунгийн дуу	6	Ре эгшиг	38
Хүүхэд нас	7	До эгшиг	39
Гацуурхан	10	Миний дотны найз	39
Туулай	10	Уярлын долоон эгшиг	40
Жалам хар	11	Тусч хүү	41
Баавгай, хэрэм хоёр	12	Би сурлаа	42
Хятад бүжиг	12	Төгөлдөр хуурч	45
Үлгэрийн баатрууд	13	Таван төл	46
Шувуухай	16	Ишиг	46
Бөжин	17	Өглөө	47
Өөрийгөө сориорой	21	Завь	50
Соль эгшиг	23	Ишиг	51
Ля эгшиг	23	Хургачин	52
Си эгшиг	24	Ёохор	55
До эгшиг	24	Чингисийн Монгол урьж байна	56
Өвөл ирлээ	25	Байгаль эхийн хүүхдүүд	57
Эрх цагаан ишиг	25	Анхны хичээл	58
Шинэ он айсуй	26	Янзага	59
Загас	29	Байгаль эхээ хайрлая	60
Хун	30	Хөдөөгийн сайхан	60
Туршилт	31	Хувдай ишигний паян	61
Мэлхий	34	Эрвээхэй	65
Дарцагтай дасгал	35	Хулгана	66
Өөрийгөө сориорой	37		

ӨМНӨХ ҮГ

Сайн байцгаана уу? Хүүхдүүд ээ!
Хичээлийн шинэ жилийн баярын мэнд хүргэе!

Хүүхдүүд та нар нэгдүгээр ангид аа хөгжмийн эгшгийн урт богиныг мэдэрч дөрөвт, наймт, бүтэн, хагас ноотоор хөгжимдөж сурсан. Хоёрдугаар ангийн хөгжмийн сурах бичиг “дуулъя”, “сонсьё”, “хөгжимдье”, “бүжиглэе”, “зохион найруулъя” гэсэн таван бүлэгтэй. Энэ хичээлийн жилд хүүхдүүд та нар сонирхолтой туршилт хийж, эгшгийн өндөр намыг мэдэрч, хөгжмийн долоон эгшигтэй танилцаж, ноотоор дуулж сурна.

Бяцхан хөгжмийн зохиолч болж аялгуу зохиож, өөрийнхөө бүтээлийг найз нөхөд, аав ээждээ дуулж сонсоно. Бүүвэйн дуунд уярч, ёохор хатиран, вальс бүжиглэж, хөгжмийн үлгэр сонсоно.

Хүүхдүүд ээ! Хөгжмийн хичээлээр сурсан дуу, бүжиг, сонссон хөгжмийн бүтээл бүр та нарын авьяас чадварыг нээн хөгжүүлж байдаг юм шүү.

БИД ЮУ СУРАХ ВЭ?



ТАНИХ ТЭМДЭГ



ДУУЛЪЯ



СОНСЪЁ



ХӨГЖИМДЬЕ



БҮЖИГЛЭЕ



ЗОХИОН
НАЙРУУЛЪЯ



Үг. О.Сундуй

ДУУЛҮЯ

Ая. С.Батболд

9 САРЫН 1

Хөгжилтэй

Хүү-хэд бү-хэн хү-сэн хү-лээ - сэн Е - сөн са-рын нэ-гэн

4 Ер бу-сылт ө-дөр Цэц-гээ төв-рээд багш-даа ирэ-хэд Цэж дүү-рэн ба-яр хоор - тэй

8 Энэ ө - дөр бид-ний бая - раа Эр-дэмд шам-дах су - раг-чийн бая - раа

12 У - хаан хайр-лах баг-шийн бая - р Уч - ран зол - гох сур - гуу-лийн бая - раа

Багачууд бүхэн баясаж хүлээсэн
 Есөн сарын нэгэн ер бусын өдөр
 Сурагчийн ширээнд номоо дэлгэхэд
 Судлах эрдэм нарны гэрэлтэй

Энэ өдөр бидний баяр
 Эрдэмд шамдах сурагчийн баяр
 Ухаанаа хайрлах багшийн баяр
 Учран золгох сургуулийн баяр

Сайн нөхдөө санаж хүлээсэн
 Есөн сарын нэгэн ер бусын өдөр
 Анд найзуудтайгаа догдлон уулзаад
 Анги дүүрэн инээд баясалтай



www.google.mn



- Хэмнэлээр алга ташаарай.
- Хэмнэлд тохируулан үгээ тод хэлээрэй.

Цэц-гээ төв-рээд багш-даа ир - хэд Цэж дүү-рэн ба - яр хоор - тэй



Үг. Г.Ганболд

Ая. В.Энхжаргал

ТОГЛОНО БИ

Дунд зэрэг

Хом-той ачаа-гаа дэн-хий-тэл өргө-дөг хо-лыг ха-ран зу-гуу-хан хөдөл-дөг

5 Хү-рэн ингэ-ний хөөр-хөн бот-гоо хөт-лөн гүйж тог-ло-ноо би

Сөөг гэхээр
Надтай чацуу
Хөөг гэхлээр
Надаас өндөр

Хүрэн ингэний
Хөөрхөн ботгоо
Хүзүүдэн ноолж
Тоглоно оо би

Үг. Н.Батсайхан

Ая. Ш.Ганхуяг

ХУНГИЙН ДУУ

Дунд зэрэг

Хон - хон ти-тэм зүү - сэн_____ Хос_ хун-гийн_ цу - ваа_____

5 Хөөр_ да-лав-чаа дэл - гээд_____ Хос-гүй у - ран нис - нэ_____

9 **Төгсгөл**
Навч-ны ая - сыг_ да - гаад_____ нуу - раа ор-хин од - но

Урьхан хаврын улирал
Уудам нутагтаа ирнэ
Уян налархай бүжгээ
Усны шувуудад гайхуулна

Налгар шар намар
Намуун хөвөөнөөс буцна
Навчны аясыг дагаад
Нуураа орхин одноо



Ая. Ц.Ургамал

ХҮҮХЭД НАС

Дунд зэрэг

Хүү-хэд бид - ний хөг-жил- тэй__ нас Хү-сэл бод-лын минь

4 амь-дар-лын жи-гүүр Хөл-ын од - дыг хоорон-доо я - рил-цаад

7 Хойч и - рээ-дүйг зөг-нөн мө-рөөд - сөн Най - зуу - даа наа-шаа и - рээ-рэй

11 Наа - дан - хан цэн - гэн бү - жиг - гээе__ Хүүх - дүү - дээ

14 хү - рээд и - рээ - рэй Хөг - жил - дөн той - рон бү - жиц - гээе

Зуун зууны түүхэнд бичигдэхээр
Зулай дээрээ гишгэн мэндэлсэн
Он цагийг хурдлан товчоолоод
Олны алхаанд хөлөө нийлүүлсэн

Найзуудаа наашаа ирээрэй
Нааданхан цэнгэн бүжицгээе
Хүүхдүүдээ хүрээд ирээрэй
Хөгжилдөн тойрон бүжицгээе



- Тэмдэглэсэн хэсгийг дуулахдаа багшийн гарын дохиог анхааралтай ажиглаарай.
- Дуулахдаа өнгө бүрийг цэвэр тод дуулахыг хичээгээрэй.

Хойч и - рээ-дүйг зөг-нөн мө-рөөд - сөн Най - зуу - даа




Дасгал 1

- Өгөгдсөн хэмжээгээр эгшгийн цувааг дуулахдаа эгшгийн өндрийн байршлыг хуруугаараа заагаарай.
- Ноотны хэмжээг зөв дуулахын тулд дотроо тоолоорой.




Дасгал 2

- Эгшгийн өндрийн зураглалыг зааж дуулаарай.



Дасгал 3


- Дасгалыг дуулахдаа эгшгийн өндрийг зааж дуулаарай.
- Хэмжээг зөв илэрхийлж дуулахын тулд дотроо тоолоорой.





Дасгал 4

- Хөгжмийн дуу авианы өндрийн зураглалаар дуулцгаая.



Он- гоц дээ- шээ хөөр- лөө хү- рэх газ- раа буу- лаа

Дасгал 5

- Оддыг холбож, эгшгийн өндрийн зураглалыг гаргаарай.
- Өндрийн зураглалыг хараад дуулцгаая. Энэ ямар дуу вэ?
- Шүлгийн утгыг бодож тохирох шинж төрх, өнгө аясыг илэрхийлэн дуулаарай.



Хөгжмийн дуу авиа нь өндөр, нам янз бүр байна.

Тав - тай нойр - соо - рой ал - сын од - оо



Дасгал 6

- Гацуурхан дууны эгшгийн өндрийн байрлалыг ажиглаад дуулаарай.
- Дуулахдаа хурууны дугаарыг баримтлан ширээн дээр хөгжимдөх мэт тоглоё.

ГАЦУУРХАН

The diagram shows a xylophone with colored blocks representing different notes. The notes are labeled with Cyrillic characters: жи-жиг, хэн, га-цуур, - хан, ө - вөл, хүй, тэн, юм, даа. The blocks are numbered 1 through 5, indicating finger positions. A circular inset shows a hand with fingers numbered 1 to 5.

Дасгал 7

- Туулай дууны эгшгийн өндрийн байрлалыг зааж дуулаарай.
- Хурууны дугаарыг баримтлан тогшиж дуулаарай.

Ая. Б.Цогоо

ТУУЛАЙ

The diagram shows the musical notation for the song 'Туулай'. It includes a melody line with notes labeled with Cyrillic characters: До, Соль, Ми, Ре, Сан, Дэл-дэн, Туулай. Below the melody is a rhythmic pattern with numbered boxes (1, 5, 3, 2, 5) and a hand diagram showing finger positions (1, 2, 3, 4, 5).



СОНСЪЁ

Э.Чойдог

ЖАЛАМ ХАР

- Хөгжмөө сонсоод, зургийн дагуу ярилцаарай.
- Хөгжмийн зохиол хэдэн хэсгээс бүтсэн бэ?
- Хэсгүүд юугаараа ялгаатай байна вэ?



- Хөгжмөө сонсоод зургийг дагуулан хурууныхаа өндгөөр зөөлөн тогшоорой.

А. хэсэг 1 зураг 4 цохилт

Б. хэсэг 1 зураг 3 цохилт



“Жалам хар” бол жигүүрт хурдан хүлгийн магтаал бүжиг.

- Хэмнэлээр хөгжимдөөрэй.

Хурдавар —————> Удаан —————> Хурдан






БААВГАЙ, ХЭРЭМ ХОЁР

- Хөгжмөө анхааралтай сонсоорой. Өгөгдсөн үгсийн тусламжтайгаар аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.
- Баавгайн дүрийг ямар хэмнэлээр, ямар эгшгээр дүрсэлсэн бэ?
- Хэрэмний хурдан шаламгай хөдөлгөөнийг хөгжимд хэрхэн дүрсэлсэн бэ?
- Баавгай, хэрэмний аялгууг харьцуулж, ялгааг тодорхойлоорой.

Хөгжилтэй, бараан, том, хөнгөн, удаан, гоёмсог, хүчирхэг, зоригтой, хурдан, чанга, зөөлөн, тогтворгүй, жижиг, зальтай, түгшүүртэй, хатуу, ширүүн




Баавгай	Хэрэм
- Удаан	-
- Хүнд	-
- Түгшүүртэй	-
- Чанга	-
- Бараан өнгө	-
- Доод эгшгүүд	-



ХЯТАД БҮЖИГ

П.И.Чайковский

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Ямар хөгжмийн зэмсгээр хөгжимдсэнийг зургаас ажиглаарай.
- Зэмсгүүд хоорондоо хэрхэн харилцаж байгааг ноот болон зураг дээрээс олж мэдээрэй.
- Хэмнэлээр тогшоорой.





ҮЛГЭРИЙН БААТРУУД

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Энэ хэн бэ? Чи яаж таньсан бэ?
- Нөхөдтэйгөө ярилцаарай.



- Сонсоорой. Хэн дуулсан бэ?
- Яаж таньсан бэ?
- Найзуудын чинь дуу хоолой ямар ялгаатай байна вэ?

Нарийн
тунгалаг



уянгалаг

намуун,
зөөлөн


хүчтэй



ХӨГЖИМДЬЕ


Дасгал 1

- Модон цэргийн маршаа сонсоод хэмнэлээр хөгжимдөөрэй.




Дасгал 2

- Гацуурхан дуугаа дуулаад, хэмнэлээр тоглоё.



Дасгал 3

- Хэмнэлээр тоглоё.





Дасгал 4

- Хэмнэлийг ажиглаарай. Хэдэн хувьтай байна вэ?
- Хэмнэлээр хөгжимдөөрэй. Хөгжимдөхийн өмнө хэмжээгээ зөв авах шаардлагатай.

1.

2.

- Доорх зэмсгүүдээр хөгжимдөөд дуугаралтын онцлогийг тодорхойлж ярилцаарай.

Хөгжмийн энгийн зэмсэг	Гурвалжин	Товшуур	Цан	Хонх

Дасгал 5

- Хэмнэлийг хөдөлгөөнөөр гүйцэтгээрэй.
- Дасгалыг багшийнхаа дохиогоор нэгэн зэрэг жигд гүйцэтгээрэй.

Дасгал 6

- Хэмнэлийн дасгалыг ажиглаарай. Дасгалыг гүйцэтгэхдээ зүүн- баруун- зүүн, баруун – зүүн- баруун гэх мэтээр нэрлэх нь амжилттай сурахад тустай.

1 и 2 и 1 и 2 и

1 и 2 и 1 и 2 и



БҮЖИГЛЭЭ

ШУВУУХАЙ

(Хөгжимт хөдөлгөөн)

- Аялгууны шинж төрхөд тохируулан шувуухайн хөдөлгөөнийг дүрсэлж бүжиглээрэй.



Шувуухай далавчаа дэлгэнэ.



Далавчаа ээлжлэн өргөнө.



Далавчаа өргөөд эргэлдэнэ.



Далавчаа дэлгэн хөлөө өргөж буулгана



Далавчаа дэлгэн сууж босно.



Далавчаа зөрүүлэн дээш өргөнө.



Далавчаа хөдөлгөн дороо эргэлдэнэ.



БӨЖИН (Хөгжимт хөдөлгөөн)

- Ая Б.Цогоо "Туулай" дууны шинж төрхөд тохируулан бөжингийн хөдөлгөөнийг дүрсэлж тоглоорой.



Бөжин туулай минь
бүжиглэхэд бэлдээрэй.



Дэрсэнд хярсан
Дэлдэн туулай



Дэргэдээс босоод
Дэгдэн харайлаа



Дээр дээр
Үсрэн үсрэн



Дэлдэн туулай
Дэнж дээгүүр



Даваад явчихлаа



Тоглох юмсан гэж
Бодоод явдаг



Томоотой жаалаас
Айгаад яана даа






ЗОХИОН НАЙРУУЛЪЯ

Дасгал 1

- Зураасуудыг ажиглаж, ямар ялгаатай болохыг ярилцаарай.
- Хуруугаараа дагуулан зааж “аа” авиагаар дуулцгаая.



- Эхний зураасаар дуулахад өнгө өөрчлөгдөхгүй нэг түвшинд байна.
- Бусад зураасаар ямар өөрчлөлт гарсан бэ? (Байрандаа, өгссөн, уруудсан, давалгаалсан)

Дасгал 2

АВЪЯАСЛАГ НАЙРАЛ ДУУЧИД

Тоглоомд удирдаач найрал дуучид оролцоно. Найрал дуучид сайн мэдэх дуугаа удирдаачийн дохиогоор дуулна. Анхааралгүй тоглогч найрал дууны хамтлагаас хасагдана.



Удирдаач гараа өргөхөд дуучид чанга дуулна.



Гараа буулгаж хагас суухад огцом зөөлөрнө.




Харин удирдаач гараа атгахад найрал дуучид чив чимээгүй болно.



Дасгал 3

- Амьтдын дуу авиаг дуурайгаарай.
- Амьтдын дуу авианы өөрчлөлтийг гараар дүрслээрэй.
- Гарын байрлал яаж өөрчлөгдсөн бэ?




Дасгал 4


- Хүүхдүүд ээ! Найзуудтайгаа хамтарч бодлого бодоцгооё.
- Хэд тоолж хөгжимдөх вэ?



Дээр дээр үсрэн
Дэнж дээгүүр дэгдэнэ



Хөөрхөн болжмор жив жив
Хөөрөн нисээд дэв дэв




Харин баавгай болон
бамбарын явдал
алхааг та нар өөрсдөө
дүрслэн тоглоорой.










Дасгал 5

- Зургийг ажиглаарай. Түүний хийж байгаа өглөөний дасгалыг үргэлжлүүлэн зохиогоорой.
- Ямар хэмнэл тохиромжтой вэ?
- Өглөөний дасгалд тохирох хэмнэл зохиогоорой.



Дасгал 6

- Өгөгдлийг ашиглан шувуухай, баавгай сэдвээр хөгжим бичигцгээе.
- Өөрсдийнхөөрөө зохион найруулаарай.

	     
---	---



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ

Зохион найруулъя.

- Хөвчийн модонд хөхөө донгодов.
- Зураглалын дагуу хөхөө болж донгодоорой. Дуу авианы өөрчлөлтийг гараараа дүрслэн үзүүлээрэй.



Бүжиглэе.

- Шүлгээ уншаад, хөгжмийн аялгуунд тохируулан бүжиглээрэй.



Хоёр гараа урдаа авч
Хоёр хөлөө нийлүүлээд
Хөнгөн хөнгөн үсрээд
Хөөрхөн туулай болцгооё



Хөлөө урагш тавиад
Хуруугаа харин сарвайлгаад
Арр арр гэж дуугараад
Араатны хаан болцгооё



9 Сонсьё. Ч.Сангидорж. “Амьтад”

- Хөгжмөөр зураг дээрх амьтдын алийг нь дүрсэлсэн бэ?
- Яаж таньсан бэ?
- Тухайн амьтныг хөгжмийн ямар эгшгээр дүрсэлсэн бэ? (өндөр, нам)
- Эгшгийн урт нь ямар байна вэ? (урт, богино)



Дуулъя.

- Өндрийн байрлалыг гараар зааж дуулаарай.

Үг. Д.Батсүрэн

Ая. Ж.Шараа

ГЭГЭЭН ӨГЛӨӨ САЙН БАЙНА УУ

Musical notation for the song 'Гэгээн өглөө сайн байна уу'. The melody is written on a staff with notes and rests. The notes are labeled with their corresponding solfège syllables: Соль, Соль, Ми, Ре, Соль, Соль, Соль, Ми, Соль, Ми, Ре, До, До, До. The notes are connected by a purple line that follows the contour of the melody.

На-майг дуу - даж сэ - рээ - сэн гэ - гээн өг - лөө сайн байна уу

- Хэмнэлээр хөгжимдье.

Rhythmic notation for the accompaniment. It consists of a series of notes on a staff, grouped into boxes below. The boxes contain the following numbers: 1 2 3 4, 1 2, 3 4, 1 2 3 4, 1 2 3 4. This indicates the fingerings for the notes.

- Өөрийгөө төгөлдөр хуураар хөгжимдөж байна гэж төсөөлөн ширээн дээрээ хурууны дугаараар тоглож, дуулъя.

- Эгшгийн тоон илэрхийлэл хурууны дугаартай тохирно.

ХӨХӨӨ



Musical notation for the 'Хөхөө' exercise. It shows a sequence of notes on a staff with fingerings indicated above them: 1 3, 1 3, 5 3, 5 3, 1 1, 1. Below the staff, the lyrics are written: Хө-хөө шу-вуу гүг-гүг гүг-гүг дон-год - но



ДУУЛЪЯ

Соль эгшиг

Соль түлхүүр

Дэвсгэр таван шугам

Багшийн хөгжимдөхийг сонсоод Соль эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.

1 и 2 и 1 и 2 и 1 и 2 и 1 и 2 и

1 и 2 и 1 и 2 и

1 и 2 и 1 и 2 и

Ля эгшиг

Соль түлхүүр

Дэвсгэр таван шугам

Ля эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.



Си эгшиг

Соль түлхүүр

Дэвсгэр таван шугам

Си эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.

До эгшиг

Соль түлхүүр

Дэвсгэр таван шугам

До эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.



Үг. Х.Соёмбо

Ая. Х.Ягаанцэцэг

ӨВӨЛ ИРЛЭЭ

Хурдан

6 Ца-сан шир-хэг бу-дарч ө-вөл ир лээ_____ Ца-сан шир-хэг

11 дуул - ж ө - вөл ир - лээ Өн - гийн гэр - лээр алаг - лаж

га - цуур чим - лээ_ Өв - гөн аав - аас бэл - гээ___ ав - лаа

- “Өвөл ирлээ” дуунд хэмнэлийн хамсраа хийж дуулаарай.

Үг. М.Чойжил

Ая. Т.Чимэддорж

ЭРХ ЦАГААН ИШИГ

Тайван

Э - зэн - дээ___ ээл - тэй и - жил - дээ___ чи - мэг - тэй

5 Эрх ца - гаан и - шиг минь хөөр - хөн - дөө хөөр - хөн

Өнөөдөр би хургачин хүү
 Өсөхөөрөө малчин
 Эрх цагаан ишгэндээ
 Хайртай даа хайртай



Үг. О.Сундуй

Ая.С.Батболд

ШИНЭ ОН АЙСУЙ

Вальс

Ца-гаан цас-хан гял-бан буу - гаад Но-гоон га-цуур

7 гоё-лоо нөм-рөөд Бага-чууд бид-ний сэт-гэл бая - саад Ба - яр цэн-гэл

15 дүү - рэн бай - наа Ай хө Шинэ он шинэ жил Зээ

22 хө Шинэ жи-лийн ү - дэш Хөг - жил - тэй сай - хан бай - наа

Өвлийн өвөө цасан охид
 Үлгэрийн хөлгөөр аялан ирээд
 Хүүхэд бүрийн алган дээр
 Хүсэл хайрын бэлэг түгээнэ.

Ай хө Шинэ он шинэ жил
 Зээ хө Шинэ жилийн үдэш
 Хөгжилтэй сайхан байна





- Хэмнэлээр хамсран хөгжимдөөрэй.



Дасгал 1

- Хэмнэлийг хурууны өндгөөр зөөлөн тогшоорой.
- Тоон илэрхийллийг ноотонд хөрвүүлж бичээд дуулаарай.
- Өөрийгөө төгөлдөр хуур хөгжим тоглож байна гэж төсөөлөн хурууны дугаарыг баримтлан тоглоод дуулаарай.
- Эгшгийн тоон илэрхийлэл хурууны дугаартай тохирно.




- Тоон илэрхийллийг ноотонд хөрвүүлж бичээд дуулаарай.
- Дуулахдаа хэмнэлээр зөөлөн тогшоорой.



Дасгал 2

ХҮҮХЭЛДЭЙ

- Хурууны дугаарыг баримтлан агаарт болон ширээн дээр тогшиж дуулаарай.
- Эгшгийн тэмдэглэгээг сайтар ажигла.



1 5 5 1 2 3 2 3 1

Хөг - лөөд яв - хад ал - хаад бай - даг _____
 Хөөр - хөн хүүхэл - дэй ма - найд бай - даг _____



Дасгал 3

- Аялгуу ямар хэмжээтэй ноотнуудаас бүтэж байна вэ?
- Багшийгаа сонсоод зураасын дагуу ноотоор дуулцгаая.
- Дуулахдаа өөрийгөө болон нөхдийгөө сонсож дуулаарай.

Дасгал 4

Бор шувуу дууг ноотоор аялгуулан дууллаа.





СОНСЪЁ

К.Сенсанс

ЗАГАС

- Хөгжмөө сонсохдоо загасыг дагуулан хуруугаараа заагаарай.
- Дээр доор байрлах жижиг загаснууд юу илэрхийлж байна вэ?
- Загаснууд яагаад том жижиг байна вэ?




Хөгжмийн дуу
 авиа урт богино,
 өндөр нам янз бүр
 эгшиглэдэг.



ХУН

- Хөгжмөө сонсохдоо эгшгийн өндрийн зураглалыг ажиглаарай.
- Хөгжмийн аялгуунд тохируулан зураглалыг хуруугаараа дагуулан зааж дотроо аялаарай.

Хөгжмийн эгшгүүд дээшээ доошоо янз бүрийн хөдөлгөөнд орж байна.



- Асуултын тэмдгийн оронд аялгууны шинж төрхөд тохирох үгсийг олж дэвтэртээ бичээрэй.

Уянгын

?

Удаан

?

Зөөлөн

?





ТУРШИЛТ

- Резин бэлтгээрэй.
- Резинээ 2 талаас нь татъя.
- Хуруугаараа татан дуу авиа үүсгээрэй.
- Резинээ богиносгож татаад дахин дуу авиа үүсгэе.
- Дуу авиа яаж өөрчлөгдсөн бэ?



- 3 ижил лонх, дэвтэр, шугам, харандаа бэлтгэцгээе.
- Дэвтэртээ шулуун шугам татаарай.
- Шилэн савандаа өөр өөр хэмжээтэй ус хийе.
- Эхлээд дундуур устай лонхны амсар уруу нь үлээж дуу авиа үүсгээрэй. Үүссэн дуу авиаг шугамны голд тэмдэглэе.
- Дараа нь их устай болон бага устай лонх уруу дээрхийн адил үлээгээрэй.
- Үүссэн дуу авианы өндрийг шугамны хаана тэмдэглэх вэ?



Авиа өндөр бол гараа дээш өргөөрэй.

Авиа нам бол гараа доош нь буулгаарай.





ХӨГЖИМДЬЕ

Дасгал 1

- Хамтран хөгжимдөцгөө.
- Хөгжмийн зэмсэг тус бүрээр давтаад бүрэн сурсныхаа дараа нийлж хөгжимдөөрэй.
- Хамсран хөгжимдөхийн тулд нөхдийгөө сонсож, багшийн дохиог анхаараарай.

Дасгал 2

- Уншаад хэмнэлээр тогшоорой.
- Үүссэн хэмнэлийг ноотонд шилжүүлж бичээрэй.

Ар	давж	хү-лэг	бол-дог
■	■	■ ■	■ ■
А - жил	хийж	хүн	бол-дог
■ ■	■	■	■ ■


Эр-дэм	төгс	хү-нийг	шүт
■ ■	■	■ ■	■
Эр-дэм	мө-хөс	хү-нийг	тэвч
■ ■	■ ■	■ ■	■

_____ ?




Дасгал 3

- Янз бүрийн хэмжээтэй хэмнэл зохиогоорой.
- Доорх хөгжмийн зэмсгүүдээс сонгон авч зохиосон хэмнэлээ хөгжимдөөрэй.



Дасгал 4

- Ноотоо уншаад хэмнэлийн дасгалыг гүйцэтгээрэй.
- Хөгжимдөхдөө тоолно бас нөхдийгөө сонсоно. Хэдэн хувь байна вэ?
- Багшийнхаа дохиог анхаарч нэгэн зэрэг жигд хэмнэлээр хөгжимдөөрэй.





БҮЖИГЛЭЭ

Үг. А.Найгалмаа

Ая. Б.Өнөржаргал

МЭЛХИЙ

(Хөгжимт хөдөлгөөн)

- “Мэлхий” дууны хэмнэлд тохируулан хөгжимт хөдөлгөөн хийцгээе.



Бэлтгэх байдал.



Гараа дээш өргөөд зүүн хөлөө ээлжлэн өргөж буулгана.



Гараа доош буулгахдаа тонгойж, гараа дээш өргөхдөө цэх зогсоно.



Доош сууж гараа урдаа авч үсэрнэ.



Баруун зүүн хөлөө ээлжлэн өлмийгөөр товшино.



Хоёр тийш ээлжлэн харж вааг вааг дуугарч үсэрнэ.





ДАРЦАГТАЙ ДАСГАЛ (Хөгжимт хөдөлгөөн)

Үг. Ая. С.Батболд “Дагаад хийгээрэй” дууны хэмнэлд тохируулан дасгалаа гүйцэтгээрэй.



Дасгалаа хийгээрэй
Дагаад хийгээрэй



Толгойгоо хөдөлгөөд
Хөлөө өргөөд




Нэг хоёр гурав дөрөв
Нэг хоёр гурав дөрөв

ЗОХИОН НАЙРУУЛЪЯ


Дасгал 1

Соль, ля, си, до эгшээр  ноотуудыг ашиглан аялгуу зохиогоорой.




Дасгал 2

- Зургийг ажиглаарай. Ямар улирал вэ? Үеэр тасалж нэрлээд алга ташаарай.
- Үүссэн хэмнэлээ ноотонд шилжүүлж бичээрэй.



ӨӨРИЙГӨӨ СОРИОРОЙ


- Дараах дэвсгэр шугам дээрх тэмдэгтүүдийг нэрлээрэй.




- Ноотоор дуулаарай.



- Хөгжмийн энгийн зэмсгүүдээр дараах хэмнэлийг хөгжимдөөрэй.




- Тоон илэрхийллийг эгшгийн нэрэнд шилжүүлээрэй.
- Дуулахдаа хурууны дугаарыг баримтлан тоглоорой.
- Харьцуулан ярилцаад ялгааг тодорхойлно уу.






ДУУЛЪЯ


Фа эгшиг




Багшийн хөгжимдөхийг сонсоод Фа эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.



Ми эгшиг



Ми эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.



Ре эгшиг




Ре эгшгийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.






До эгшиг




До эгшигийг янз бүрийн хэмнэлээр дуулаарай.



Үг. Ая. С.Батболд

МИНИЙ ДОТНЫ НАЙЗ

Хөнгөвтөр



Ми-ний дот-ны найз бол До

До ре ми фа соль ля си

C D E F G A B
1 2 3 4 5 6 7

Хөгжмийн эгшиг



Үг. О.Сундуй

Ая. С.Батболд

УЯРЛЫН ДОЛООН ЭГШИГ

Хөгжилтэй

5

9

13

Хүү - хэд бид - ний сэт - гэлд хүс - лийн цэн - хэр аял - гуу

Хүж — дэл - хийн гай - хам - шиг Хөгж - мийн до - лоон эгш - гээ

До ре ми фа соль ля си

До - лоон өнгө до - лоон уян - гаа

Үлэмжийн сайхныг урлах
 Бийрийн торгон үзүүр
 Үзэх нүдний гайхамшиг
 Зургийн долоон өнгөө

Найган ганхах цэцэгсийн
 Мэлмий баясах агшин
 Нартай борооны эгшиглэн
 Солонгын долоон өнгөө



Цэгтэй ноот байна.

сэт - гэлд аял - гуу

1 и 2 и 1 и 2 и

до - ре ми фа соль ля си

1 и 2 и 1 и 2 и 1 и 2 и 1 и 2 и



Үг. Т.Жамъянсүрэн

Ая. Б.Цэнджав

ТУСЧ ХҮҮ

Дунд зэрэг

4

9

Хөрш ай - лын ө - вөө маань А - дуу - гаа ху - раа - гаад

явж байна Хөөр - хөн уна - гаа бари - хад нь ам - даж о - чоод тус - лана даа

Өв - гөн аа - ваас минь Өөрц юув Ө - вөө на - дад ба - яр - лана даа

Саахалт айлын эмээ маань
Хувингаа бариад явж байна
Саалийн үнээгээ саахад нь
Тугалыг нь татаад тусална даа

Үеийн бяцхан нөхөд минь
Өндөр настанд тустай даа
Өвөө эмээ хоёрт би
Өөрийн хэрээр тусална даа

Эмгэн ээжээс минь
Ялгаа юув
Эмээ надад баярлана даа

Өвгөн ааваас минь
Өөрц юув
Өвөө надад баярлана даа



Хэмжээ
солигдож
байна.

2

3

хөрш ай - лын ө - вөө маань

өв - гөн аа - ваас минь



Ая, үг. С.Батболд

БИ СУРЛАА

Дунд зэрэг

Бү-тэн, ха-гас — дө-рөвт, наймт. Ар-ван зур-гаат — хэм-нэ-лийг

8 — Хөг-жим-дөж бас — тог-лож сур-лаа —

13 До до до до До ре ми Фа фа фа фа фа соль ля си си до

Ноотны таван шугаман дээр
 Үндсэн долоон эгшгээ би
 Дуулж, бичиж, тоглож сурлаа

До До До До, До Ре Ми
 Фа Фа Фа Фа, Фа Соль Ля
 Си Си До



Зогсцын
 тэмдэг байна.

Бү - тэн ха - гас —

дө - рөвт наймт —

до до до до до ре ми



Дасгал 1

- Зургийг ажиглаарай.
- Өгөгдсөн эгшгээс хөдөлгөөний чиглэлийн дагуу аялгууны хэсгийг бүтээж үсгээр болон ноотоор илэрхийлье.
- Бичсэнээ ноотоор дуулцгаая.

E ? ? G ? ?

E ? ? G ? ?

E ? ? G ? ?

E ? ? G ? ?

E ? ? G ? ?



Дасгал 2

- Эгшгүүдийн хөдөлгөөнийг анхааралтай ажиглаад, ялгааг олж ярилцаарай.
- Эгшгийн хөдөлгөөнийг анхааралтай сонсож дуулаарай.

1. 
 Ү - зэг барь - сан турь-хан гарт минь____ Үг хол-бох ар - гыг__

2. 
 Хүү - хэд бид - ний хөг-жил- тэй_ нас Хү-сэл бод-лын минь

Хөгжмийн эгшгүүд өөр хоорондоо зохицон холбогдож аялгууг үүсгэдэг. Аялгуу нь өнгө эгшгээ давтах, дараалан өгсөх, уруудах, өнгө алгасч үсрэх зэрэг хөдөлгөөнүүдээс бүтдэг.

Жишээ нь: “Туулай” дууны ноотыг ажиглацгаая.


- Эгшгүүдийн хөдөлгөөнийг тодорхойлж зөв дуулаарай.




Дэл - дэн туу - лай Дэнж дээ - гүүр да - ваад яв - чих - лаа




Дасгал 3







- Зургийг ажиглаад эгшгүүдийн хөдөлгөөнийг тодорхойлоорой.
- Ноотонд шилжүүлж бичээд дуулаарай.
- Дуулахдаа баруун гарын хурууны дугаарыг баримтлан ширээн дээр тоглоорой.



До	Ре	Ми	Фа	Соль	Ля	Си
1	2	3	4	5	6	7



1.   

2.      



СОНСЪЁ

К.Сен- санс

ТӨГӨЛДӨР ХУУРЧ

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Зураглалыг ажиглаад аялгууны чиглэл хөдөлгөөнд тохирохыг олж тайлбарлаарай.
- “Төгөлдөр хуурч” зохиолыг сонсоод аялгууны хөдөлгөөнийг өөрийнхөөрөө зураглаарай.

1.



2.



ТӨГӨЛДӨР ХУУР


Төгөлдөр хуур бол 80 гаруй өнгө эгшгийг дуурьсгах чадалтай хөгжмийн зэмсэг.

Монголын хөгжмийн зохиолч С.Гончигсумлаа, Ч.Сангидорж мөн Оросын хөгжмийн зохиолч П.И.Чайковский, С.Прокофьев нар хүүхдүүд та нарт зориулж төгөлдөр хуурын олон сайхан аязууд бичсэн. Тэдгээр хөгжимд хүүхдийн баяр хөөр, уйтгар гуниг, хөгжилтэй мөчүүдийг дүрслэн илэрхийлсэн байдаг.




ТАВАН ТӨЛ

- Таван хошуу малын төлийг нэрлээд, төл тус бүрийн төрх араншинг ярилцаарай.
- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжимд ямар амьтныг дүрсэлсэн бэ?
- Аялгууны шинж төрх ямар байна вэ? Шүлэгтэй холбон тайлбарлаарай.
- Аялгууны хурд ямар байсан бэ?



Шүлгийг уншаад зураглалын дагуу аялгуу зохиогоорой.

Дээш дээш дэгдээд
 Дэргэд нь очвол зугтаад
 Хад чулуунд дүүлээд
 Хаашаа ч хамаагүй үсчээд
 Ишиг мөн ч сэргэлэн дээ
 Ижилсэн тоглох нь соньхон доо





- Ноотоо хараад хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Эгшгүүд ямар чиглэлд хөдөлж байна вэ?
- Дараах аялгууг хөгжмийн ямар ямар зэмсгээр ээлжлэн хөгжимдөж байгааг зургаас ажиглаж мэдээрэй.

Э.Григ

ӨГЛӨӨ

Удаан тайван






ХӨГЖИМДЬЕ

Цэг тухайн ноотыг тал хувьтай нь тэнцэх хэмжээгээр уртасгана.

$\text{♩} = 1\ 2$ $\text{♩} = 1\ 2 + 1$




Дасгал 1

- Дараах ноотны хэмжээг зөөлөн тогшоорой.
- Хэдэн хувь байна вэ?
- Нийлбэрийг олоорой.

A collection of musical rhythm exercises. On the left, five pairs of notes are shown in yellow rounded rectangles: (1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter, 1. quarter), and (1. quarter, 1. quarter, 1. quarter). In the center, three purple stars are arranged vertically, each containing a note: a quarter note, a dotted quarter note, and a quarter note. A dashed orange arrow points from the first pair of notes on the left to the first star. On the right, five pairs of notes are shown in yellow rounded rectangles: (1. quarter, 1. quarter, 1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter, 1. quarter), (1. quarter, 1. quarter), and (1. quarter, 1. quarter).

Дасгал 2

- Хэмнэлээр хөгжимдье.
- > Тэмдгийг анхаарч хүчтэй хувийг чанга тоглоорой.




A musical staff with two lines. The top line contains four measures of music. Each measure starts with a quarter rest, followed by a quarter note. The first and third measures have a 'v' accent mark under the quarter note. The second and fourth measures have a 'v' accent mark under the quarter rest. The bottom line contains four measures of music. Each measure starts with a quarter note, followed by a quarter rest. The first and third measures have a 'v' accent mark under the quarter note. The second and fourth measures have a 'v' accent mark under the quarter rest. The staff ends with a double bar line.




Дасгал 3

- Багшийнхаа дохиог анхаарч нэгэн зэрэг жигд хэмнэлээр нөхдийгөө сонсон гүйцэтгээрэй.




Дасгал 4

- Хэмнэлээр хөгжимдье. Хоолой бүрийг тусад нь давтаж сурсны дараа хоёр хоолой хамт хөгжимдөнө.
- Хөгжимдөхдөө багшийн дохиог анхаарч нөхдийгөө сонсоорой.



Дасгал 5

- Ноотыг ажиглаад хэдэн хувьт хэмжээ болохыг тодорхойлоорой.
- Хэмнэлээр зөөлөн тогшоорой.





БУЖИГЛЭ

ЗАВЬ (Хөгжимт хөдөлгөөн)

- Аялгууны хэмнэл, шинж төрхөд тохируулан завиа сэлүүрдэж тоглоцгооё.



Урагшаа хойшоо сэлүүрдье
Урт завь минь хөвөөрэй



Баруун зүүн тийш сэлүүрдье
Бяцхан завь минь хурдлаарай



Жигдхэн жигдхэн сэлүүрдье
Жижигхэн завь минь хөвөөрэй



ИШИГ (Хөгжимт хөдөлгөөн)

- Аялгууны хэмнэл, шинж төрхөд тохируулан ишигний үсэрч дүүлэх, цовхчих, харайх, эрхлэн тоглох хөдөлгөөнийг дүрслэн тоглоцгооё.





ХУРГАЧИН (Хөгжимт хөдөлгөөн)

- Хөгжмөө сонсоод зургийн дагуу дүрд хувирч тоглоцгооё.



Хургаа хариулахаар
хургачин охин гарлаа.

Хуудас үлгэр уншаад
хургачин маань унтчихлаа.



Аадар бороо
орлоо.

Нэг хурга
маань алга.

Эрж зөндөө
хайлаа.

Ээждээ юу гэж
хэлнэ дээ.



Хургаа ч оллоо,
зөндөө ч зэмлэлээ.

Баяр хөөрөөр дүүрэн
баясан бүжлээ.

Инээд өвөрлөн
гэртээ харилаа.



ЗОХИОН НАЙРУУЛЪЯ



Дасгал 1

- Эхний шатаар дуулъя. Дараагийн шатанд орхигдсон эгшгийг дэвтэртээ нөхөж бичээд дуулаарай. Сүүлийн шатанд ямар эгшгүүдийг алгассан байна вэ?
- Дэвтэртээ бичээд дуулаарай.



Дасгал 2




- Өгөгдсөн эгшгийг зураглалын дагуу дэвсгэр шугамд байруулаарай.
- Бичиж тэмдэглэсэн аялгуугаа гарын дохио ашиглан ноотоор дуулаарай.
- Чиний мэддэг дуу байгаа шүү.








Дасгал 3

- Хэмнэлээр тогшоод алдааг олж илрүүлээрэй.



Дасгал 4

- Зураглалыг ажиглаад хэдэн хувь болохыг тодорхойл.
- Өгөгдсөн айзам хэмжээнд байж болох утгыг олоорой.






ДУУЛЪЯ

Буриад ардын дуу

ЁОХОР

- Бүүвэйн дуу, Ёохор бүжгийн аялгууг харьцуулан сонсоцгооё.
- Ёохор бүжгийн аялгуу бүүвэйн дуунаас ямар ялгаатай байна вэ?
- Ёохор бүжгийн аялгуу ямар өнгө аясыг илэрхийлж байна вэ?
- Дэвтэртээ харьцуулан бичээрэй.



- Зургийг ажиглаарай.
- Хэмнэлийг илэрхийлэх дүрс аялгууны шинж төрх болон хэмжээг хэрхэн илэрхийлснийг ажиглаад ярилцаарай.
- Дуу тус бүрийн өнгө аясыг илэрхийлж хэмнэлээр хөгжимдөцгөө.
- Ямар ялгаатай байна вэ?

Ёохор



Бүүвэйн дуу



Баруун гараараа агаарт тоглож дуулъя.



то - хойн чи - нээ га - зар - таа



той - рон байж ха - тирь -яа





- “Чингисийн Монгол урьж байна” дууны зогсоцтой хэсэгт хөгжмийн энгийн зэмсгээр хэмнэлийн хамсраа хийж дуулаарай.
- Дууны утга агуулгыг ярилцаарай.

Үг.Т.Бямбарагчаа

Ая. Д.Чулуун

ЧИНГИСИЙН МОНГОЛ УРЬЖ БАЙНА

Дунд зэрэг

Мор-ин хуу-рын а - ял - гуу я - мар гоё - ыг чаг-наа-рай чаг-наа-рай

6
Морь-тон ар-дын ая дуу я-мар сайх-ныг гай-хаа-рай гай-хаа-рай ай__ хө__

13
Чин са-наат Чин зо-ригт Чин сэт-гэлт Чинги-сийн Мон-гол урьж бай - на

Манай Монгол нутаг
Ямар уудмыг хараарай, хараарай
Малчин түмний сэтгэл
Ямар уужмыг үзээрэй, үзээрэй

Хөх тэнгэрийн шидээр
Онгодоо дуудаж баясаарай, баясаарай
Хүлэг морины зоон дээр
Хиймороо бадрааж аялаарай, аялаарай

ЧИН СЭТ-ГЭЛТ ЧИНГИ - СИЙН МОН - ГОЛ

- “Би сурлаа”, “Чингисийн монгол урьж байна” дуунуудын утга агуулга, аялгууны шинж төрхийг харьцуулаарай.

Би сурлаа	Чингисийн Монгол урьж байна
- ?	- Тэнүүн уужим
- Хурдавтар	- ?
- Чанга	- ?



Үг.Ж.Дашдондог

Ая.Г.Пүрэвдорж

БАЙГАЛЬ ЭХИЙН ХҮҮХДҮҮД

Дунд зэрэг

Хээ- рийн_ амь-тад-тай нө-хөр- лөс_ гэвч Хэ-лийг нь даанч_____

4 Ойл-гох-гүй юм Хэ- цүү-хэн цагт нь тус_ дая_ гэвч хэр-хэх л уч-раа о-лох-гүй юм.

9 Ай бид чинь бай-галь гэд-эг нэг эх-тэй байж Ам-хэ-лээ юун даа_ эс ойл-гоно вэ?

13 Ай бид чинь дэл-хий гэд-дэг нэг гэр-тэй байж Аль али-наа юунд эс ойл-гоно вэ?

Ойн шувуудтай ярилцъя гэвч
 Орчуулах хүн олдохгүй юм
 Ойртож дотносож явъя гэтэл
 Ойлгуулах аргаа мэдэхгүй юм

Усны амьтадтай уулзъя гэвч
 Ухаанд нэг л багтахгүй юм
 Уйтгар зовлонг нь хуваалцъя гэвч
 Учрыг нь сайн олохгүй юм

- Зураглалыг ажиглаад хэмнэлээр алга ташаарай.

- Дээрх дууны аль хэсгийн хэмнэлтэй адил байна вэ?

A musical exercise consisting of a row of 11 notes on a single staff. Above the notes are illustrations of flowers of varying sizes and orientations. The first seven notes are quarter notes, the eighth is a half note, and the ninth is a whole note. The flowers are: a large white flower with a yellow center, a small white flower, a small white flower, a small white flower, a small white flower, a small white flower, a small white flower, a large white flower with a yellow center, a small white flower, a small white flower, and a large white flower with a yellow center.



Үг. Ая. Д.Оюунтүлхүүр

АНХНЫ ХИЧЭЭЛ

Дунд зэрэг

До реми фа соль ля си до гээд до-лоон өн-гөө нэр-лэж сур-ъя даа

До ре ми фа соль ля си до гээд Дур-тай хөгж-мөө тог-лож сур-ъя даа

дуу-гаа дуу-лаад бүж-гээ хий-гээд дот-ны най-зууд-даа зааж сур-гая-даа

дуу-гаа дуу-лаад бүж гээ хий - гээд дот-ны най-зууд - даа зааж сур-гая - даа

А Б В Г Д гээд
 А-гаас Я хүртэл уншъя даа
 Нэг хоёр гурав дөрөв тав гээд
 Нэгээс зуу хүртэл тоолъё доо

<p>Нуман холбоос байна.</p>	<p>- ноотын хэмжээг нэгтгэж тоглоно.</p>	<p>Хэмнэлийг гүйцэтгээрэй.</p> <p>тоолоорой</p>
-----------------------------	--	---



СОНСЪЁ

ЯНЗАГА

- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Хөгжмөөр ямар үйл явдлыг дүрсэлж байна вэ?
- Аялгуу хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Хэсэг тус бүрийн аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.



- Уншаад аялгууны шинж төрх, эгшиглэх хүч, хөгжимдөх хурдад тохирох хариултыг сонгоод дэвтэртээ тэмдэглээрэй.

Хурдан

Намуун тайван

Бараан хүнд

Хөгжилтэй

Намуун тайван

Түгшүүртэй

Янзага эхийнхээ дэргэд амгалан тайван нойрсоно.

Хөвч хангайд эрх янзага дураараа тоглон наадна.

Эхээсээ төөрсөн янзага араатны дунд ганцаараа хоцров.

Удаан

Бүрхэг саарал

Зөөлөн

Чанга

Яруу зөөлөн

Хөөрхийлөлтэй




Ц.Намсрайжав

ХУВДАЙ ИШИГНИЙ ПАЯН
(Хөгжимт үлгэр)

- Хөгжимт үлгэрээ сонсоод, зургийн дагуу ярилцаарай.





Зөв хариултыг сонгож дэвтэртээ бичээрэй.
Жишээ нь:

Өглөөний ая


Уужим тэнүүн
Хурдан цоглог
Баатарлаг

Сүхээгийн ая

Зөрүүд
Хөгжилтэй цовоо
Уйтгартай

Ишиг

Удаан тайван
Цовоо сэргэлэн
Гуниглуун



Гайхамшигтай
Элэгсэг дотно
Түгшүүртэй


Анхааралтай
Зоригтой
Баатарлаг

Залхуутай
Аймшигтай
Баяр хөөртэй
Түгшүүртэй



БАЙГАЛЬ ЭХЭЭ ХАЙРЛАЯ

- Зургийг ажиглаарай. Чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ?
- Зургаас хөгжмийн ямар хүчийг мэдэрч байна вэ?
- Зургийг аялгууны ямар шинж төрхөөр илэрхийлж болох вэ?



- Хөгжмөө анхааралтай сонсоорой.
- Уншаад эгшиглэлтийн хүчийг тодорхойлж бичээрэй.

Хурц тод, гялалзсан өнгө бадрангуй.....эгшиглэнэ.

Бүрхэг бүүдгэр өнгө гуниглуун.....эгшиглэнэ.

Ц.Нацагдорж



ХӨДӨӨГИЙН САЙХАН



- Хөгжмөө сонсоод аялгууны шинж төрхийг тодорхойлоорой.
- Хөгжимд чухам юу дүрслэгдсэнийг ярилцаарай.

Тайван, удаан, уужим тэнүүн, уянгалаг, зөөлөн гэсэн үсгийг оролцуулан сонссон хөгжмийнхөө тухай шүлэг зохиогоорой.



ХӨГЖИМДЬЕ

Цээж бичиг гэдэг бол сонссон өгүүлбэрээ аль болох алдалгүйгээр цээжээр бичихийг хэлдэг. Харин хөгжмийн хичээл дээрх цээж бичиг арай өөр. Юу вэ? гэвэл чи багшийн өгсөн үгийг хэмнэлээр соль. Ингээд л гүйцээ. Жишээ нь: “Бөмбөр”

- Энэ үг хэдэн үеэс бүтсэн бэ?
- Үгээ үеэр тасалж хэлээд зөөлөн тогшоод үзээрэй.
- Энэ үгийг хэмнэлээр солиход хэдэн цохилт болж байна вэ?
- Үгийн өргөлт хаанаа байна вэ?

бөм - бөр	бөм - бөг	цэ - цэг	хөг - жим
аав	ээж	ах	эгч
Цэн - гэл	Тог - тох	Цэл - мэг	Ман - дах

Дасгал 1

- Дараах үгсийг хэмнэлээр илэрхийлээрэй.

Дэвтэр, ном
Ном, дэвтэр

Эрдмийг хичээлээр
Эрлийг сургаар

Дасгал 2

- Хэмнэлээр хөгжимдье.
- Хүчтэй хувийг хэрхэн тэмдэглэдэг вэ?
- Хүчтэй хувийг тэмдэглээд тод чанга хөгжимдөөрэй.



Дасгал 3

- Хэмнэлээр хөгжимдье.
- Хэмнэлээ тогшиж үзээд хэдэн хувь болохыг тодорхойлоорой.

1. 


2. 


3. 

4. 

Дасгал 4


- Хэмнэлээр хөгжимдье.
- Хоолой тус бүрт хүчтэй хувийг олж тэмдэглээрэй.
- Хоёр хоолойгоор хөгжимдөхдөө нөхдийгөө сонсоорой.






Дасгал 5

- Гурван хоолойгоор хэмнэлээр хөгжимдье.
- Зогсоцтой хэсгийг анхаараарай. Ямар хэмжээтэй ноотны зогсоцууд байна вэ?
- Багшийнхаа дохиог анхаарч нэгэн зэрэг жигд хэмнэлээр хөгжимдөөрэй.







БҮЖИГЛЭЭ

ЭРВЭЭХЭЙ (Хөгжимт хөдөлгөөн)

– Аялгууны хэмнэл, шинж төрхөд тохируулан эрвээхэйн хөдөлгөөнийг дуурайж, хамтарч тоглоорой.



Бяцхан авгалдай хоол хайна.



Өдөр ирэх тусам авгалдай аажим аажмаар өслөө.



Авгалдай ядраад унтлаа.



Авгалдай сэрээд эрвээхэй боллоо.



Эрвээхэйнүүд гоёхон далавчаа дэвэн нислээ.



Үг. Ц.Нүүдэл

Ая. Ч.Алтансүх

ХУЛГАНА (Хөгжимт хөдөлгөөн)

- Хулганы гүйх, үсрэх, харайх, тоглон наадах хөдөлгөөнийг дуурайн бүжиглэцгээе.



Хөдөлгөөнөө хийцгээе,
хулганууд аа



Сэм сэмхэн гишгээрэй



Сэргэлэн хулганууд минь
эргэлдээрэй



Өөд өөдөөсөө
хараарай



Өөдөсхөн хулганууд
минь зөрөөрэй



Урд хөлөө өргөөрэй



Урагшаа хойшоо
бүжиглээрэй






ЗОХИОН НАЙРУУЛЪЯ


Дасгал 1

- Өгөгдсөн хэмнэлийг ажиглаад, алдааг олоорой.
- Дэвтэртээ засаж бичээд, хэмнэлээр хөгжимдөөрэй.



Дасгал 2

- Хэмнэлийг ажиглаад, өгөгдсөн хэмжээнд тохируулан өөрийнхөөрөө зохиож бичээрэй.



Дасгал 3

- Хэмнэлээр тогшоод, өгөгдсөн хэмжээгээр айзмын зураас татаарай.



Дасгал 4

- Зураглалыг ажиглаад, өгөгдсөн эгшгээс хөдөлгөөний чиглэлийн дагуу аялгуу зохиоцгооё.
- Ноотонд шилжүүлж бичээд дуулаарай.





Дасгал 5

- Хэмнэлээр тогшоод нийлбэрийг олоорой.

1а. + + =

1б. + + + + =

1в. + + + + =

Дасгал 6

- Өгөгдсөн хэмжээнд тохирох урттай ноотыг нөхөж бичээрэй.

2а. + + + =

2б. + + =

2в. + + + =

Дасгал 7

- Зураглалыг ажиглаад хэдэн хувь болохыг тодорхойлоорой.

- Өгөгдсөн айзам хэмжээнд байж болох утгыг олоорой.

Diagram 1: Left box contains a quarter note and a dotted quarter note. Right box contains a quarter note. Below the line are two question marks over a quarter note symbol.

Diagram 2: Left box contains a quarter note, a quarter note, and a quarter note. Right box contains a quarter note, a quarter note, and a quarter note. Below the line are two question marks over a quarter note symbol.

Diagram 3: Left box contains a question mark, a quarter note, a dotted quarter note, and a quarter note. Right box contains a quarter note, a quarter note, and a quarter note. Below the line are a '5' over a quarter note symbol and a question mark over a quarter note symbol.